



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар A/102

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах  
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 5.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Тасралтгүй тэжээлийн систем UPS болон батерей нийлүүлэх (Улаанбаатар, Хөвсгөл, Төв, Хэнтий, Өмнөговь, Сүхбаатар аймаг)” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:

П.Гантөгс Агаарын навигацийн үйлчилгээний газрын менежер

Нарийн бичгийн дарга:

Ч.Ганзориг Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн

Гишүүд:

Ж.Батбаяр Холбоо, навигаци, ажиглалтын албаны Техник төлөвлөлт инженерингийн хэсгийн технологич инженер

Г.Ганзориг Монголын Аэронавигаци, инженер техникийн ажилтнуудын холбооны гишүүн

Ш.Нямбаяр “ХУД ЯАРМАГ” Төрийн бус байгууллагын Гүйцэтгэх захирал

2. Нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (П.Гантөгс)-нд үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендер нээхэд Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Хуулийн хэлтэст хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА

П.МОНХЖАРГАЛ

